



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 5/21

Модот

Шагнаж урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн "Улсын үзлэг зохион байгуулах тухай" 23 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ийн 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2025 оны А/649 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах, үзлэгийг зохион байгуулахад идэвх санаачлагатай ажиллаж, амжилттай 92,6%-тай үнэлэгдсэн тул Сумын Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгч Е.Нармандахыг сарын үндсэн цалингийн 20 хувиар шагнасугай.

2.Дээрх зардалд зарцуулагдах хөрөнгийг цалин сангийн зардлаас тооцож олгохыг Санхүү албаны Нягтлан бодогч (Б.Буяндэлгэр)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн (И.Найманцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ү.ИЧИНХОРЛОО